



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2024/05/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Даланзадгад хот 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: С.Одончимэг Утас: 70533552 Цахим хаяг: Odonchimegs@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2024.03.25 № 297

танай _____-ны № _____-т

ДАЛАНЗАДГАД СУМЫН ЗАСАГ ДАРГА
Х.БАТБОЛД ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Даланзадгад сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Даланзадгад сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлын онцолсон хэсэг

Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компаниудтай хамтран агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний хүрээнд “Энержи ресурс” ХХК-тай гэрээ байгуулан сумын галлаагаатай 74 аж ахуй нэгж, 7499 өрхөд 20.000 тн угаасан нүүрсийг түгээх ажлыг зохион байгуулсан байна.

Аудитын гол асуудал

Даланзадгад сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор хөтөлбөр, төсөл арга хэмжээнд 4,499.3 сая төгрөг баталснаас гүйцэтгэлээр 3,216.1 сая төгрөг зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Даланзадгад сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2023 оны 13/2 дугаар тогтоолоор Даланзадгад сумын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 91.4 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

016020519

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		8,587,130.1	16,631,222.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	4,476,538.5	12,050,462.6
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	4а, 4б	0.0	0.0
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	797,257.0	722,495.3
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	0.0	798.0
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	2,109,103.8	2,376,377.1
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	0.0	91,292.1
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	1,204,230.7	1,389,797.1
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		129,112,182.0	136,553,894.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	129,112,182.0	136,553,894.0
39100	Газар		0.0	0.0
39200	Биет хөрөнгө		128,077,078.9	135,521,718.8
39300	Биет бус хөрөнгө	13	1,035,103.1	1,032,175.2
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	14	0.0	0.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		137,699,312.1	153,185,116.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		626,390.0	487,799.8
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	626,390.0	487,799.8
41100	Богино хугацаат үнэт цаас		0.0	0.0
41200	Богино хугацаат зээлийн өглөг	16а, 16б	0.0	0.0
41300	Өглөг	17а, 17б	101,370.2	67,408.7
41400	Урьдчилж орсон орлого	18а, 18б	525,019.8	420,391.1
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		137,072,922.1	152,697,316.4
51	Засгийн газрын хувь оролцоо		137,072,922.1	152,697,316.4
51100	Засгийн газрын оруулсан капитал		27,850,010.7	27,850,010.7
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/		484,597.4	484,597.4
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/		0.0	19,665.4
51200	Хуримтлагдсан үр дүн		108,563,499.1	124,178,628.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зерүү		174,814.9	164,414.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		137,699,312.1	153,185,116.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		51,912,282.2	54,726,684.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО		17,235,449.2	27,089,100.8
110	Орлогын албан татвар		16,314,618.1	25,346,553.2
1100	Хувь хүний орлогын албан татвар		17,205,275.9	26,104,549.2
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-890,657.7	-757,996.0
113	Хөрөнгийн албан татвар		519,970.9	796,393.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж		400,860.2	946,154.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	14,818,635.6	24,412,945.6
120	Нийтлэг татварын бус орлого		14,566,779.9	24,412,945.6
121	Хөрөнгийн орлого		251,855.8	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		19,858,197.4	3,224,637.7
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	52,792,897.1	37,429,874.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ		52,792,897.1	37,429,874.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		26,659,036.8	30,247,341.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		3,987,604.6	5,859,822.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		509,711.9	787,581.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		1,406,223.2	521,053.4
2104	Хангамж, бараа материалын зардал		694,603.7	3,357,774.6
2105	Нормативд зардал		454,712.5	441,949.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		465,248.6	395,008.6
2107	Томилолт, зочны зардал		21,996.8	40,696.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		3,615,914.1	4,848,301.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		15,503,021.3	13,995,154.9
211	ХҮҮ		0.0	0.0
212	ТАТААС		0.0	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		26,133,860.4	7,182,532.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		0.0	0.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		-880,614.9	17,296,809.8
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		0.0	0.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		48,802,737.2	1,723,049.6
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		-49,683,352.1	15,573,760.3

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
11	2023 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	137,072,922.1	0.0	137,072,922.1
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	50,634.1	0.0	50,634.1
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	137,123,556.2	0.0	137,123,556.2
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчлөлт	0.0	0.0	0.0
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	15,573,760.3	0.0	15,573,760.3
20	2023 оны 12-р сарын 31-аарх үлдэгдэл	152,697,316.4	0.0	152,697,316.4

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан /мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		42,666,746.7	34,217,615.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО		17,235,449.2	26,611,751.9
110	Орлогын албан татвар		16,314,618.1	24,869,204.4
1100	Хувь хүний орлогын албан татвар		17,205,275.9	25,627,200.4
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-890,657.7	-757,996.0
113	Хөрөнгийн албан татвар		519,970.9	796,393.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж		400,860.2	946,154.6
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж		193,252.0	700,794.6
1181	Газрын төлбөр		206,294.6	203,089.9
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр		1,313.5	42,270.1
1183	Бусад татвар		0.0	0.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		5,573,100.1	4,381,225.5
120	Нийтлэг татварын бус орлого		5,321,244.4	3,903,876.6
121	Хөрөнгийн орлого		251,855.8	477,348.8
122	Тусламжийн орлого		0.0	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		19,858,197.4	3,224,637.7
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		37,534,626.6	23,691,291.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ		37,534,626.6	23,691,291.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		11,323,272.2	16,242,901.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		4,008,082.7	5,898,031.3

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		523,739.5	769,144.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		1,423,675.8	535,299.8
2104	Хангамж, бараа материалын зардал		757,918.2	928,704.7
2105	Нормативт зардал		281,822.8	198,052.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		477,740.5	406,534.3
2107	Томилолт, зочны зардал		21,996.8	40,696.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		3,524,968.1	4,912,187.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		303,327.7	2,554,249.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		26,211,354.4	7,448,390.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		5,132,120.1	10,526,323.5
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)		0.0	0.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		3,152,363.7	2,952,399.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		3,152,363.7	2,952,399.4
2200	Дотоод эх үүсвэрээр		3,152,363.7	2,952,399.4
2260	Гадаад эх үүсвэрээр		0.0	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		-3,152,363.7	-2,952,399.4
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		1,979,756.4	7,573,924.1
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		2,496,782.1	4,476,538.5
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		4,476,538.5	12,050,462.6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	24,643,028.10	18,022,409.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	20,121,246.60	15,362,664.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	17,582,972.30	14,144,732.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,096,027.80	4,680,017.36
210101	Үндсэн цалин	2,981,699.20	2,716,744.90
210102	Нэмэгдэл	1,296,723.20	1,126,867.69
210103	Унаа хоолны хөнгөлөлт	623,544.00	551,034.63
210104	Урамшуулал	194,061.40	285,370.15
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	667,993.40	614,979.00
210201	Тэтгэврийн даатгал	434,560.20	416,363.82
210202	Тэтгэмжийн даатгал	50,972.60	45,329.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	78,653.00	58,318.88
210204	Ажилгүйдлийн даатгал	9,437.00	8,616.00
210205	Эрүүл мэндийн даатгал	94,370.60	86,350.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,424,194.10	2,017,657.97
210301	Гэрэл, цахилгаан	546,579.60	480,693.04
210302	Түлш, халаалт	1,425,373.20	1,187,012.20
210303	Цэвэр, бохир ус	444,741.30	349,952.72
210304	Байрны түрээс	7,500.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	924,665.80	814,837.91
210401	Бичиг хэрэг	86,000.00	57,547.87
210402	Тээвэр, шатахуун	532,400.00	500,027.97
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	37,477.60	32,686.17
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	63,000.00	52,294.88
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	205,788.20	172,281.03
2105	Нормативт зардал	66,000.00	41,234.65
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,000.00	427.25
210502	Хоол, хүнс	0.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	65,000.00	40,807.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	876,210.40	811,455.25
210601	Багаж, техник, хэрэгсэл	156,000.00	145,052.60
210602	Тавилга	0.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	49,642.70	22,970.10
210604	Урсгал засвар	670,567.70	643,432.55
2107	Томилолт, зочны зардал	50,801.00	23,279.10
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	50,801.00	23,279.10
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,626,719.30	4,844,567.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,626,719.30	4,844,567.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	850,360.50	296,704.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	786,360.50	245,133.85
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	64,000.00	51,570.65
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,538,274.30	1,217,931.52
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	2,354,782.90	1,053,219.40
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	2,354,782.90	1,053,219.40
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	0.00	0.00

2132	Бусад урсгал шилжүүлэг	183,491.40	164,712.13
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33,551.40	30,899.55
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	149,940.00	133,812.57
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,521,781.50	2,659,745.50
223001	Бусад хөрөнгө	4,521,781.50	2,659,745.50
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	24,643,028.10	19,189,421.39
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.00	1,980,204.60
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	0.00	1,980,204.60
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	23,789,626.50	16,990,675.79
320001	Орон нутгийн төсвөөс	21,809,421.80	16,990,675.79
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	1,980,204.70	0.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	853,401.60	218,541.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	309,000.00	218,541.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	544,401.60	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	544,401.74
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	1,711,413.26

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,269,990.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,265,440.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	351,324.45
2104	Хангамж, бараа материалын зардал	21,667.69
210401	Бичиг хэрэг	952.00
210402	Тээвэр, шатахуун	10,514.68
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,201.02
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,620.50
210604	Урсгал засвар	18,620.50
2107	Томилолт, зочны зардал	864.00
210702	Дотоод албан томилолт	864.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,199.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,199.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	305,972.76
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	300,052.76
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,920.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	914,115.93
2132	Бусад урсгал шилжүүлэг	887,694.47
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	887,694.47
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	26,421.46
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	26,421.46
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,550.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,550.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,550.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,269,990.39
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,269,990.39
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,154,267.64
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,535.72
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	111,187.03
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,581.4 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 2,581.4 сая төгрөгийн алдааг залруулж ажиллалаа. Үүнд:

- Санхүүгийн үр дүнгийн тайланд үйл ажиллагааны орлогыг 598.5 сая төгрөгөөр илүү илэрхийлсэн,
- Санхүүгийн үр дүнгийн тайланд хичээл үйлдвэрлэлийн зардлыг 1.2 сая төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 0.5 сая төгрөгөөр тус тус дутуу, албан томилолтын зардлыг 1.0 сая төгрөгөөр илүү илэрхийлсэн,
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд улсын төсвөөс санхүүжих орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн шилжүүлгийн төлөвлөгөө 1,980.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжих гэж тус тус тайлагнасан байгаа нь санхүүгийн тайлангийн толилуулга, ангилал гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Аудитаар нийт 953.1 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 605.9 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 347.2 сая төгрөгийн зөрчилд 6 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй байна.

5.2 Албан шаардлага

-Төрийн албан хаагчид, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин хөгжүүлэх, туршлага судлуулах төсөл арга хэмжээ болон Эрүүл иргэн-Хөгжлийн тулгуур хөтөлбөрийн хүрээнд төрийн албан хаагчид, хувиараа бизнес эрхлэгчдийг нийт 344.9 сая төгрөгийн хөрөнгөөр Япон, БНХАУ-д туршлага судлуулсан боловч орон нутагт нэвтрүүлсэн үйлдвэрлэл үйлчилгээ, шинэ санал санаачилга гараагүй, төсвийг үр дүнгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

-Оюуны үр хөтөлбөрөөс төрийн албан хаагчдын эмчилгээний зардал, орон сууц худалдан авах дэмжлэг, цэвэр бохирын төвлөрсөн шугамд холбох, орон гэргүй зорилтод бүлгийн албан хаагчдад нийт 261.0 сая төгрөгийн дэмжлэг олгосон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.21-д "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хөрөнгөөр хандив, тусламж, түүнтэй адилтгах аливаа хөтөлбөр, арга хэмжээ, нийгмийн шинжтэй үйл ажиллагаа, төсвийн алдагдлыг санхүүжүүлэхийг хориглоно", Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10-д "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт 1: Тус төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаа ирүүлэхдээ төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсгийг хангаж ирүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна", санхүүгийн тайлангийн иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуульд заасны дагуу төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсгийн хангаж ажиллаж

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт 2: "Говийн Ирээдүй" ОНӨААТҮГ-ын эд хөрөнгийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх талаар гэрээ хэлцэл хийгээгүй, тус байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго тодорхой бус, 26.4 сая төгрөгийн өр төлбөр, 23.6 сая төгрөгийн авлагатай, тайлант онд ашиггүй ажилласан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 "эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, хүргэх түвшин", 78 дугаар зүйлийн 78.2.1 "иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олгосон эрх хэмжээний дотор орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах"-д заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Говийн Ирээдүй ОНӨААТҮГ-ын үр ашгийг дээшлүүлэх, удирдлага зохион байгуулалтаар хангах, холбогдох бусад арга хэмжээг авч ажиллах

Илрүүлэлт 3: Даланзадгад сумын төсөвт байгууллагуудад чанарын менежментийн стандартыг нэвтрүүлэх ажлын гэрээг хэсэгчлэн байгуулж "Төвлүүн говь" ХХК-аар нийтдээ 49.9 сая төгрөгөөр гүйцэтгүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-д "хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох, зөрчлийг давтан гаргахгүй байх, худалдан авах ажиллагааны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах

Илрүүлэлт 4: Даланзадгадад үйлдвэрлэв хөтөлбөрөөс малчдад цаг үеийн мэдээ, мэдээллийг түргэн шуурхай хүргэх зорилгоор нийт 9.9 сая төгрөгийн өртөгтэй 4 ш таблет, 1 ширхэг принтер, автомат хөргүүр, вакцин хөргүүр бэлтгэсэн, ангилагдаагүй нөөц хөрөнгөөс аймгийн Цагдаагийн газарт 12.8 сая төгрөгийн өртөгтэй бэлэн бус торгуулийн тоног төхөөрөмжийг нийлүүлсэн нь хөтөлбөрийн зорилгод нийцээгүй, хөрөнгө оруулалтын зардлын шинжтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"-д заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөтөлбөрийн зорилгод нийцүүлэн арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтын шинжтэй зарлага санхүүжилт гаргахгүй байх

Илрүүлэлт 5: Рояаль Олон Улсын Их Сургуулийн магистрын "Төрийн удирдлага"-д хөтөлбөрт суралцаж байгаа төрийн албан хаагчдын сургалтын төлбөрт 28.8 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох"-д заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Зайлшгүй шаардлагатай боловсон хүчнийг мэргэшүүлэхээс бусад ахисан түвшний сургалтын төлбөрт төсвөөс хөрөнгө зарцуулахгүй байх, зөрчлийг арилгаж ажиллах

Илрүүлэлт 6: Сумын ИТХ-ын 2021 оны 3/5 дугаар тогтоолын дагуу малын тоо толгойн албан татварт толгой тутамд 2000 төгрөг ногдуулж, 2022, 2023 оны малын тоо толгойн албан татварын 245.9 сая төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлээгүй, холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", 60 дугаар зүйлийн 60.2.8 "малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, орлогын эх үүсвэрийг бүрдүүлж төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх, холбогдох арга хэмжээг авч ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн үр дүнгийн тайланд үйл ажиллагааны орлогыг 598.5 сая төгрөгөөр илүү илэрхийлсэн	1	598.5			1	598.5	1	598.5				
Санхүүгийн үр дүнгийн тайланд хичээл үйлдвэрлэлийн зардлыг 1.2 сая төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 0.5 сая төгрөгөөр тус тус дутуу, албан томилолтын зардлыг 1.0 сая төгрөгөөр илүү илэрхийлсэн	1	2.7			1	2.7	1	2.7				
Төсвийн гүйцэтгэлийн тайланд улсын төсвөөс санхүүжих орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн шилжүүлгийн төлөвлөгөө 1,980.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжих гэж	1	1,980.2			1	1,980.2	1	1,980.2				
Дүн	3	2,581.4			3	2,581.4	3	2,581.4				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төрийн албан хаагчид, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин хөгжүүлэх, туршлага судлуулах төсөл арга хэмжээ болон Эрүүл иргэн-Хөгжлийн тулгуур хөтөлбөрийн хүрээнд төрийн албан хаагчид, хувиараа бизнес эрхлэгчдийг нийт 344.9 сая төгрөгийн хөрөнгөөр Япон, БНХАУ-д туршлага судлуулсан боловч орон нутагт нэвтрүүлсэн үйлдвэрлэл үйлчилгээ, шинэ санал санаачилга гараагүй, төсвийг үр дүнгүй зарцуулсан байна.	1	344.9			1	344.9						
Оюуны үр хөтөлбөрөөс төрийн албан хаагчдын эмчилгээний зардал, орон сууц худалдан авах дэмжлэг, цэвэр бохирын төвлөрсөн шугамд холбох, орон гэргүй зорилтод бүлгийн албан хаагчдад нийт 261.0 сая төгрөгийн дэмжлэг олгосон байна.	1	261.0			1	261.0						

Тус төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаа ирүүлэхдээ төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсгийг хангаж ирүүлээгүй байна.	1	0				1	0			
"Говийн Ирээдүй" ОНӨААТҮГ-ын эд хөрөнгийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх талаар гэрээ хэлцэл хийгээгүй, тус байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго тодорхой бус, 26.4 сая төгрөгийн өр төлбөр, 23.6 сая төгрөгийн авлагатай, тайлант онд ашиггүй ажилласан байна	1	0				1	0			
Даланзадгад сумын төсөвт байгууллагуудад чанарын менежментийн стандартыг нэвтрүүлэх ажлын гэрээг хэсэгчлэн байгуулж "Төвлүүн говь" ХХК-аар 49.9 сая төгрөгөөр гүйцэтгүүлсэн байна.	1	49.9				1	49.9			
Даланзадгадад үйлдвэрлэв хөтөлбөрөөс малчдад цаг үеийн мэдээ, мэдээллийг түргэн шуурхай хүргэх зорилгоор нийт 9.9 сая төгрөгийн өртөгтэй 4 ш таблет, 1 ширхэг принтер, автомат хөргүүр, вакцин хөргүүр бэлтгэсэн, ангилагдаагүй нөөц хөрөнгөөс аймгийн Цагдаагийн газарт 12.8 сая төгрөгийн өртөгтэй бэлэн бус торгуулийн тоног төхөөрөмжийг нийлүүлсэн нь хөтөлбөрийн зорилтод нийцээгүй, хөрөнгө оруулалтын зардлын шинжтэй байна.	1	22.6				1	22.6			
Рояль Олон Улсын Их Сургуулийн магистрын "Төрийн удирдлага"-д хөтөлбөрт суралцаж байгаа төрийн албан хаагчдын сургалтын төлбөрт 28.8 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.	1	28.8				1	28.8			
Сумын ИТХ-ын 2021 оны 3/5 дугаар тогтоолын дагуу малын тоо толгойн албан татварт толгой тутамд 2000 төгрөг ногдуулж, 2022, 2023 оны малын тоо толгойн албан татварын 245.9 сая төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлээгүй, холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.	1	245.9				1	245.9			
Дүн	8	953.1			2	605.9	6	347.2		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Шилэн дансны мэдээлэлд аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлтийн төлөвлөгөө, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийг тус тус мэдээлээгүй байна	1	0						1	0
Дүн	1	0						1	0